

## "НОМИН ДААТГАЛ" ХХК

1. Даатгуулагчийн зөвшөөрөлгүй этгээд автотээврийн хэрэгслийг жолоодож яваад осол гаргасан;
2. Даатгуулагч болон түүний зөвшөөрөлтэй этгээд осол болох үед
  - 2.1 согтууруулах ундаа, мансууруулах бодис, сэтгэцэд нөлөөлөх эм хэрэглэсэн байсан;
  - 2.2 зохих байгууллагын дүгнэлтээр хэт ядарсан, автомашин жолоодох чадамжгүй байсан нь тогтоогдсон;
  - 2.3 жолоодох эрхгүй байсан;
3. Даатгуулагчийн сонгосон хамгаалалтын төрөлд ороогүй болон нэмэлт хураамж төлж даатгуулагчий эрсдлүүдийн улмаас учирсан хохирол, түүний үр дагавар;
4. Хуучрах, зэврэх, ердийн элэгдэл болон үйлдвэрийн гологдол /дефект/;
5. Үйлдвэрийн бус нэмэлт тоноглол хэрэгслүүдийг тээврийн хэрэгслийн үнэлгээн дээр нэмж үнэлж даатгуулагчий тохиолдолд түүнд учирсан гэмтэл;
6. Даатгуулагч автотээврийн хэрэгслийг зайлшгүй зогсолтоос бусад шалтгаанаар замын зорчих хэсэгт зогсоосон үед учирсан хохирол;
7. Хулгайн эрсдэлээс нэмж даатгуулсан тохиолдолд эмблем, антенн, гаднах жижиг чимэглэл, улсын дугаарын хулгай хамаарахгүй;
8. Даатгуулагч даатгагчид мэдэгдэхгүйгээр даатгалын зүйлд учирсан хохирлоо ямар нэгэн хэлбэрээр төлүүлсэн, харилцан тохиролцсон;
9. Нөхөн төлбөр шийдвэрлэгдээгүй байхад даатгагчтай зөвшилцөлгүйгээр автотээврийн хэрэгслийг устгасан, зарсан;
10. Даатгалтай автотээврийн хэрэгслийг уралдаан тэмцээнд ашигласан, хурд хэтрүүлсэн, даац хэтрүүлсэн;
11. Урсгал сөрсөн, замын зохицуулагч болон зохицуулах дохио зөрчсөн болон зайлшгүй шалтгаанаас бусад тохиолдолд замын зорчих боломжгүй хэсгээр зорчсон /замын хашлага, ногоон байгууламж, явган зорчигчийн зорчих талбай/;
12. Ажлын тормосны систем, жолооны механизм ажиллахгүй болсон, чиргүүлийн холбоос эвдэрсэнээс үүсэн учирсан хохирол буюу уг эвдэрлийг замын хөдөлгөөнд оролцохоос өмнө мэргэжлийн байгууллага тогтоогдсон байх;
13. Харанхуй буюу үзэгдэлт хангалтгүй үед зөв талын хол, ойрын болон ар талын оврын гэрлүүд асахгүй болсоноос учирсан хохирол буюу уг эвдэрлийг замын хөдөлгөөнд оролцохоос өмнө мэргэжлийн байгууллага тогтоосон байх;
14. Дугуйн хэмжээ, даац нь тээврийн хэрэгслийн тухайн төрөлд тохироогүй болон нэг тэнхлэгт өөр марк, хээтэй дугуй тавьсанаас учирсан хохирол;
15. Цас бороо орж байгаа үед жолоочийн талын шил арчуур ажиллагаагүй байснаас учирсан хохирол ба уг эвдэрлийг замын хөдөлгөөнд оролцохоос өмнө мэргэжлийн байгууллага тогтоосон байх;
16. Даатгуулагчийн хууль бус үйлдлийн улмаас учирсан хохирол;
17. Хохирол гарсан шалтгаан, байрлал, хугацааны аль нэг нь тодорхойгүй нотлох боломжгүй гарз хохирол;
18. Автотээврийн хэрэгсэл болон эзэмшигч өөрчлөгдсөн талаар даатгагчид мэдэгдэж даатгалын баталгааг шинэчлээгүй;
19. Хүндэтгэн үзэх шалтгаантайгаас бусад тохиолдолд цагдаагийн байгууллагад аваар осол, хулгайн талаар газар дээр нь мэдэгдэж үзлэг шалгалт хийлгэн акт дүгнэлт гаргуулаагүй, гэрээнд заасан хугацаанд даатгагчид мэдэгдэж, хохиролтой холбоотой материалыг даатгагчид ирүүлээгүй;
20. Цацраг идэвхит бодис, цөмийн зэвсэг, цөмийн түлш, тэсрэх бөмбөг бусад тэсрэх бодис, байлдааны зэвсгийн үйлчилгээнээс үүдэлтэй шууд болон шууд бус үр дагавараас шалтгаалсан хохирол болон даатгалтай автотээврийн хэрэгслийг тэсрэх шатах аюул бүхий бодис, бүтээгдэхүүн ачиж зөөвөрлөхөд ашигласны улмаас учирсан хохирол;

21. Дайн байлдаан, улс төрийн болон террорист үйл ажиллагаа, ажил хаялт, төрийн эргэлт, бослого, үймээн самууны үр дагавар.